



ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ГАЗАР

1. ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ
2. ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/
3. ДАГАЖ ГАРАХ ХУУЛИЙН ТӨСЛҮҮД



/ /

**ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурал 2003 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Төрийн аудитын тухай хуулийг баталсан бөгөөд өнгөрсөн хугацаанд тус хуульд 10 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Эдгээр нэмэлт, өөрчлөлтийг оруулах явцад анх батлагдсан хуулийн 58 хувь нь өөрчлөгдөж, хуулийн бүтэц, нэр томьёо, хэсэг, заалт хоорондын уялдаа алдагдсан байна. Тухайлбал, 2006 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн, 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн, 2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиудаар оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь Төрийн аудитын тухай хуулийн нийт зохицуулалтын 50-аас дээш хувьд оруулсан нэмэлт, өөрчлөлт юм. Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалтад “өмнө нь тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нь нэмэлт, өөрчлөлт орсон бол” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахаар заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтөд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэсэн зорилт нэмсэн.

Практик шаардлага

Төрийн аудитын тухай хуулийг шинэчлэн найруулах дараах практик шаардлага тулгарч байна. Үүнд:

1.Төрийн аудитын тухай хуулийн төрийн аудитын байгууллагын чиг үүргийг Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зохицуулалттай харьцуулан үзвэл төрийн аудитын байгууллага нь улс, орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, үйл ажиллагааны гүйцэтгэлд аудит хийх буюу төрийн аудитын байгууллагыг санхүүгийн болон гүйцэтгэлийн аудит хийх чиг үүргийг хэрэгжүүлэх байдлаар тодорхойлсон байна.

Үүнийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд заасан “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэсэн зохицуулалттай нийцүүлэх шаардлагатай.



2.Төрийн аудитын тухай хуульд 2013 оны 11 дүгээр зүйлийн 07-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулахдаа “Төрийн аудитын төрөл” гэсэн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт “Нийцлийн аудит нь аудит хийлгэсэн байгууллага үйл ажиллагаандаа хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актаар тогтоосон шаардлагыг сахин биелүүлж байгаа байдлыг шалгаж дүгнэлт, зөвлөмж гаргана” гэж нэмж, төрийн аудитын байгууллага “нийцлийн аудит” хийхээр зохицуулсан боловч хуулийн үйлчлэх хүрээ болон хуулийн бусад хэсэгт энэ талаар ямар нэг нарийвчилсан зохицуулалтыг тусгаагүй байна.

Иймд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд нийцлийн аудитыг хэрхэн хийх, аудит хийсний үр дүнд ямар шийдвэр гаргах харилцааг хуульд нэмж тусгах шаардлагатай болсон.

3.Төрийн аудитын тухай хуулийн 3 дугаар зүйлд “Төрийн аудитын үндсэн зарчим”-д “хараат бус байх” зарчмыг тусгаагүй, мөн бусад зүйл, хэсэгт ч үүнийг тодорхой зохицуулаагүй байна. Практик дээр хууль хяналтын байгууллагууд аудиторуудыг гаргасан дүгнэлт, мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан шалгах, буруутгах, гэрчийн мэдүүлэг авах зэрэг асуудал нилээд гардаг бөгөөд энэ нь төрийн аудитын байгууллагын хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх эрсдлийг үүсгэж байна. Иймд төрийн аудитын байгууллагын хараат бус байдлын зарчмыг хэрэгжүүлэх зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн хуульд тусгах шаардлагатай байна.

4.Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлд төрийн аудитын байгууллага үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан төсөвтэй байхаар, Монгол Улсын Ерөнхий аудитор төрийн аудитын байгууллагын төсвийн төслийг хянуулахаар Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд оруулахаар, Төсвийн байнгын хороогоор хянагдаж зөвшөөрөгдсөн төсвийн төслийг улсын төсөвт нэгтгүүлэхээр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасны дагуу хүргүүлэхээр” заасан хэдий ч “бодит байдал дээр Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос хянаж зөвшөөрөгдсөн Төрийн аудитын байгууллагын төсвийн төслийг Сангийн яам хянан хасч байгаа¹” нь төрийн аудитын байгууллагын төсвийн хараат бус байдлыг алдагдуулж байгаа тул зөвшөөрөгдсөн төсвийг хасахгүй байх зохицуулалтыг хуульчлан тусгах шаардлагатай байна.

¹ Үндэсний аудитын газраас 2018 оны 01 дүгээр сард УИХ-ын Төсвийн байнгын хороогоор 2019 онд гүйцэтгэх аудитын сэдвийг зардалтай нь тооцож батлуулсан боловч Сангийн яам аудитын зардлыг хассан бөгөөд энэ асуудлаар Үндэсний аудитын газар Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар гээд бүх шатны байгууллагуудад хандсан боловч батлагдсан төсөвтөө багтааж аудит хийх шаардлагатай гэсэн хариу өгч байжээ. <http://www.parliament.mn/n/x3co>

Мөн энэ талаар Үндэсний аудитын газрын Стратеги удирдлагын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Д.Энхболд 2019.05 сард “Синдикат ярилцлага #26”-д оролцож “Төрийн аудитын байгууллага үнэн зөв дүгнэлт гаргахад шаардлагатай санхүүжилт, төсвөө өөрөө төлөвлөж батлуулдаг байх шаардлагатай. Гэтэл Засгийн газраас төсвийн хувьд хараат, тэднийг хянах байгууллага нь тэднээр өөрсдөөр нь төсвөө хянуулж байгаа нь олон улсын зарчим стандартад нийцэхгүй байгаа юм. Үүнийг Төрийн аудитын тухай хуульд оруулсан боловч бодит байдал дээр энэ заалт хэрэгждэггүй. Гэрээт аудит ажиллуулах, мэргэжлийн байгууллагуудын туслалцаа авах зэрэг шаардлага гарч, түүнийгээ төсөвтөө суулгах асуудал гардаг. Гэтэл Сангийн яам энэ төсвийг хянаад хасчихдаг” хэмээн ярьж байжээ. <https://ikon.mn/opinion/1ax7>



5.Төрийн аудитын дээд байгууллагын удирдлагыг хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын сонгуулийн хугацаанаас урт хугацаанд тогтвортой ажиллуулах зарчмыг баримталдаг. Ийм ч учраас Төрийн аудитын тухай хуульд Ерөнхий аудиторын бүрэн эрхийн хугацааг 6 жил байхаар заасан. Гэвч Төрийн аудитын тухай хууль 2003 онд батлагдсанаас хойш Ерөнхий аудитор 6 жилийн бүрэн эрхийн хугацаагаа дуустал ажилласан нэг л тохиолдол байна. Харин бусад томилогдсон Ерөнхий аудитор бүрэн эрхийн хугацаанаасаа өмнө чөлөөлөгджээ. Ерөнхий аудиторын ажилласан бүрэн эрхийн хугацааны дундаж хугацааг тооцоход 2,6 жил байна. Монгол Улсын Их Хурлын 2012 оны ээлжит сонгуулийн дараа Ерөнхий аудиторыг бүрэн эрхийн хугацаа нь дуусаагүй байхад чөлөөлж байсан бөгөөд энэ тохиолдол 2016 оны сонгуулийн дараа мөн адил давтагдсан байна.

Иймд Ерөнхий аудиторын томилгоог улс төрийн зорилгоор хугацаанаас нь өмнө огцруулах, чөлөөлөх асуудал гаргахгүй байх хуулийн зохицуулалтыг бий болгох.

6.Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо аудитын сэдвийг батлахдаа Үндэсний аудитын газрын боловсруулсан сэдвийн нэр өөрчлөх, сэдэв нэмэх, хасах талаар одоогийн дагаж мөрдөж байгаа хуульд нарийвчлан зохицуулалт байхгүй. Үүний улмаас Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо хүний болон санхүүгийн нөөц, хугацааг бодитой төлөвлөж, тооцолгүйгээр шинээр сэдэв нэмэх, аудитын сэдвийн хамрах хүрээг өргөтгөх, багасгах тохиолдол байнга гарч байгаа бөгөөд энэ нь Төрийн аудитын тухай хууль, бусад хуулиар Төрийн аудитын байгууллагын заавал хийх аудитыг хатуу зааж хуульчилснаар төрийн аудитын байгууллага өөрөө аудит хийх сэдвээ судалж, эрсдэл, чанараа тооцоолж, үр ашигтайгаар аудит хийх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж төсөв, санхүү, хүний нөөцийн хувьд хүндрэл үүсгэж байна.²

Иймд төрийн аудитын байгууллагад аудит хийх сэдвээ өөрөө чөлөөтэй сонгох эрх хэмжээг хуулийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд олгох нь зүйтэй.

7.Аудитын дээд байгууллагын хараат бус байдлын тухай Мексикийн тунхаглалаар Мэдээлэлд хязгаарлалтгүй нэвтрэх зарчмыг тунхаглаж “Аудитын дээд байгууллага нь хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагаа зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх баримт бичиг, мэдээллийг хугацаанд нь, шууд, чөлөөтэй авах боломжийг бүрдүүлэхүйц эрх мэдэлтэй байх ёстой” гэсэн байдаг. Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлд төрийн аудитын байгууллагын мэдээлэл авах эрхийг хуульчилсан боловч уг бүрэн эрх нь бусад хууль тогтоомжоор хязгаарлагдсан³, практик дээр хэрэгжилтэд нь бэрхшээл учирч байгаа тул төрийн аудитын байгууллагын мэдээлэл авах бүрэн эрхтэй холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох.

² Төрийн аудитын байгууллагын 2017 онд гүйцэтгэх аудитын нийт 22 сэдвийн 12 нь хуулийн дагуу хийх аудит, 2018 онд гүйцэтгэх аудитын нийт 37 (8 нь өмнөх оноос шилжсэн аудит) сэдвийн 15 нь хуулийн дагуу хийх аудит, төрийн аудитын байгууллагын өөрийн бодлогоор гүйцэтгэх аудитын сэдэв 4, 2019 онд гүйцэтгэх аудитын нийт 32 сэдвийн 18 нь хуулийн дагуу хийх аудит, төрийн аудитын байгууллагын өөрийн бодлогоор гүйцэтгэх аудитын сэдэв 6 байснаас үзэхэд төрийн аудитын байгууллага аудитын сэдвээ өөрөө сонгох боломж хязгаарлагдмал байгаа нь харагдаж байна. УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02, 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоол, 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 01 дүгээр тогтоол.

³ Тухайлбал Банкны тухай хуулийн 7.2-т заасан “Банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц” гэж үзсэн.



8.Төрийн аудитын тухай хуулиар төрийн аудитын байгууллагаас акт тавих, албан шаардлага өгөх харилцааг зохицуулсан хэдий ч уг харилцааг нарийвчлан зохицуулах, журам батлах, эрх хэмжээ олгох асуудлыг боловсронгуй болгох.

9.Монгол Улсын Их Хурлаас 2011 онд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг, 2012 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг тус тус шинэчлэн найруулж батлахдаа дагалдуулан Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Уг нэмэлт, өөрчлөлт нь Төрийн аудитын тухай хуулийн “үйлчлэх хүрээ”-ээс хальсан шинжтэй, “Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, орон нутгийн сонгуульд нэр дэвшигч, нам, эвслийн сонгуулийн хандив, санхүүжилт, зардалд болон сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Төсвийн тогтвортой байдлын тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцсэн байдалд болон хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаарх эдийн засгийн тооцоог хянаж дүгнэлт гаргах” гэсэн бүлэг зохицуулалтын хэрэгжилтийн үр нөлөө тодорхойгүй байна. Энэхүү зохицуулалт нь Төрийн аудитын тухай хуулийг анх баталсан хуулийн үзэл баримтлал, зорилготой нийцээгүй, төрийн аудитын байгууллагыг улс төрийн шинжтэй харилцаа, маргаанд татан оруулах эрсдэл бий болгож, төрийн аудитын байгууллагын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж төсөв, санхүү, хүний нөөцийн хувьд хүндрэл үүсгэж байгаа тул уг зохицуулалтыг хасах шаардлагатай байна. Энэ асуудлыг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн хуульд тусгах.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд уг төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээг дээр дурдсан үндэслэл, шаардлагад нийцүүлэн боловсруулсан.

Хуулийн төслийн зорилго нь төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх, татвар болон татварын бус орлого, байгалийн баялгийн ашиглалтаас бүрдсэн нийтийн өмчийг зохистойгоор төлөвлөх, тайлагнах, ашиглах, зарцуулах ажлын үр дүнд тавих хяналтын эрх зүйн үндсийг тогтооход оршино.

Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл 6 бүлгээс бүрдэх бөгөөд хуулийн төсөлд дараах асуудлыг тусгана.Үүнд:

1.Хуулийн төслийн **нэгдүгээр бүлэгт** хуулийн зорилго, төрийн аудитын тухай хууль тогтоомж, төрийн аудитын үйл ажиллагааны үндсэн зарчим, нэр томьёо, үндсэн зорилт, төрийн аудитын байгууллагын бүрэн эрхтэй холбогдсон зохицуулалтыг тусгана.

Тухайлбал, төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээнд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийж, хуульд заасан шийдвэр гаргахаар тусгана.

2.Хуулийн төслийн **хоёрдугаар бүлгээр** төрийн аудитын төрөл, хэлбэр, цахим мэдээллийн аудит, санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэлийн аудит, нийцлийн аудит, аудитын төлөвлөлт, төлөвлөгөөт бус аудит, төрийн аудитын улсын салбарын олон улсын стандарт, шалгагдагч этгээдийн үүрэг, санхүүгийн



тайлангийн аудитыг аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх, аудитын үйл ажиллагаанд шинжээч, мэргэжилтэн оролцуулах, аудитын үйл ажиллагаанд оролцогчийг тодорхойлох, төрийн аудитын үйл ажиллагааны бүтээгдэхүүн, акт, албан шаардлага үйлдэх, акт, албан шаардлагыг мэдэгдэх, акт, албан шаардлагын биелэлтийг хангах асуудлыг зохицуулна.

Мөн төрийн аудитын байгууллагын албан хаагч аудит хийх үедээ мэдээллээр бүрэн хангагдах зарчмыг нарийвчлан тусгаж, шалгагдагч этгээдийн ажлын байр болон бусад холбогдох газарт ажлын цагаар саадгүй нэвтрэн орох, ажиллах, бүртгэл, тооллого хийх, мэдээлэл, баримт бичиг болон бусад эд зүйлстэй үнэ төлбөргүй танилцах; шалгагдагч этгээдийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа тоног төхөөрөмж, программ хангамж, мэдээллийн санд нэвтрэх, цахим мэдээлэл, баримт бичигтэй танилцах, уг мэдээлэл, баримт бичгийг цахим болон бусад хэлбэрээр хувиран авах; тайлбар гаргуулах, тодорхой асуулт тавьж хариулт авах; шаардлагатай тохиолдолд мэдээлэл, баримт бичгийг хамгаалах зорилгоор шалгагдагч этгээдийн агуулах, өрөө, сейфийг түр хугацаагаар битүүмжлэх асуудлыг тусгана.

3.Хуулийн төслийн **гуравдугаар бүлэгт** төрийн аудитын байгууллагын тогтолцоо, албан хаагчийн бүрэлдэхүүн, ангилал, зэрэг дэв, албан хаагчид тавигдах шаардлага, албан хаагчийн тангараг, ерөнхий аудиторын бүрэн эрх, тусгай аудитор, төрийн аудитын байгууллагын албан хаагчийн үүрэг, төрийн аудитын байгууллагад хийх, ерөнхий аудиторыг томилох асуудлыг нээлттэйгээр нэр дэвшсэн этгээдүүдийн дундаас Улсын Их Хурлын Эдийн засгийн, Төсвийн болон Хууль зүйн байнгын хорооноос хэлэлцэн нэр дэвшүүлсэн хүмүүсээс Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилохоор тусгана.

4.Хуулийн төслийн **дөрөвдүгээр бүлэгт** Ерөнхий аудитор Улсын Их Хуралтай харилцах, Ерөнхий аудитор Засгийн газартай харилцах, төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг төлүүлэх үүргийн хэрэгжилтийг мэдээлэх асуудлыг Үндэсний аудитын газрын цахим хуудсанд олон нийтэд нээлттэй танилцах боломжтойгоор байршуулах, төрийн аудитын үйл ажиллагааны ил тод байдлыг хангахтай холбогдсон асуудлыг тусгана.

5.Хуулийн төслийн **тавдугаар бүлгээр** Ерөнхий аудиторыг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг, нэгжлэг хийх, хуульд зааснаас бусад үндэслэлээр Ерөнхий аудиторыг албан тушаалаас нь чөлөөлөх, огцруулах, түдгэлзүүлэх, түүнчлэн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд томилох хууль зүйн баталгаа, Төрийн аудитор бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулсан, аливаа дарамт, шахалт, хууль бус нөлөөллийн талаар Ерөнхий аудиторт мэдүүлэх нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, Төрийн аудитын байгууллагын төсөв нь төрийн аудитын байгууллага үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй байх эдийн засгийн баталгаа, нийгмийн баталгаатай холбогдсон харилцааг зохицуулна.

6.Хуулийн төслийн **зургадугаар бүлэгт** Санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээдийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, санхүүгийн тайлангийн аудитаар удаа дараа хязгаарлалтай дүгнэлт авсан, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, актыг биелүүлээгүй, зөвлөмжид заасан ажлыг хэрэгжүүлж тогтоосон



хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу ирүүлээгүй тухайн төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгжийн албан хаагчийг ажлаас үүрэгт ажлаас нь халах хүртэлх арга хэмжээ авах, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар тус тус тусгах болно.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хууль батлагдан гарснаар Төрийн аудитын байгууллагын аудит хийх шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй, хараат бус, бие даасан, хууль зүй, эдийн засаг, хөндлөнгийн зүй бус нөлөөллөөс ангид байх баталгаа хангагдана.

Түүнчлэн, аудитын олон улсын стандартыг баримтлах, шалгагдагч этгээд төрийн аудитын байгууллага хооронд үүсдэг хууль хэрэглээтэй холбоотой маргаан буурах, төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг төлүүлэх үүргийн хэрэгжилтийг мэдээлэх боломж бий болох, төрийн аудитын акт, албан шаардлагын биелэлт заавал хангагдах нөхцөл бүрдэнэ.

Хуулийг нэр мөр ойлгох хүрээнд хоёрдмол утга бүхий зохицуулалтыг засах замаар хуулийн хийдлийг арилган, хуулийг төрийн аудитын байгууллага, шалгагдагч этгээд хэрэгжүүлэхэд хялбар, харилцан ил тод болгохоор өөрчлөлтүүдийг оруулж өгсөн нь цаашид тус хуулийн хэрэгжилтийн шатанд үүсч байгаа хүндрэл, бэрхшээлийг арилгах үр нөлөөтэй.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн сөрөг нөлөө байхгүй.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн тухай

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй хамт Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төсвийн тухай хууль, Банкны тухай хууль, Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

---oOo---



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь нийтийн сан хөмрөгийг хуримтлуулах, хуваарилах, ашиглах, зарцуулах төрийн санхүүгийн чиг үүргийн хэрэгжилтэд тавих хараат бус хяналтын тогтолцоог бүрдүүлж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад оршино.

2 дугаар зүйл.Төрийн аудитын тухай хууль тогтоомж

2.1.Төрийн аудитын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, Захиргааны ерөнхий хууль, Төсвийн тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Төрийн аудитын үндсэн зарчим

3.1.Төрийн аудит хийхэд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасан тусгай зарчмаас гадна дараах зарчмыг баримтална:

- 3.1.1.хараат бус, бие даасан байх;
- 3.1.2.мэргэшсэн байх;
- 3.1.3.мэдээллээр бүрэн хангагдах;
- 3.1.4.улсын салбарын аудитын олон улсын зарчим, стандартад нийцсэн байх.

4 дүгээр. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."нийтийн сан хөмрөг" гэж Монголын ард түмний нийтлэг ашиг сонирхлын төлөө зарцуулах, ашиглах эсхүл зарцуулсан, ашигласан байгалийн баялаг, төсвийн орлого, нийтийн болон тусгай сан, улсын зээллэг, гадаад зээл, тусламж, хандив, үнэт цаас, төрийн болон орон нутгийн өмчийн биет болон биет бус хөрөнгө, хувь, хувьцааг;

4.1.2."төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээ" гэж нийтийн сан хөмрөгтэй холбогдох хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, эргэж төлөгдөх нөхцлөөр



ашиглуулах болон бусад аливаа үйл ажиллагаа, өртөг нөхөгдөх зардал, хувьчлал, дуудлага худалдаа, техник, эдийн засгийн үндэслэл, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, концесс, бүх төрлийн гэрээ, хэлцлийн төлөвлөлт, тайлагналт, гүйцэтгэл, үйл ажиллагааны үр дүнд хяналт хийхийг;

4.1.3."төрийн аудитын байгууллага" гэж төрийн аудитыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Үндэсний аудитын газар, аймаг, нийслэл дэх төрийн аудитын газар, төрийн аудитын байгууллагын албан хаагчийг;

4.1.4."шалгагдагч этгээд" гэж аудит хийгдэж буй төсвийн байгууллага, нийтийн болон тусгай сан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд, түүнчлэн хуульд заасны дагуу төрийн аудит хийгдэх аливаа этгээдийг;

4.1.5."аудитэд оролцогч" гэж шалгагдагч этгээдтэй санхүү, эдийн засгийн харилцаанд оролцсон иргэн, хувийн эрх зүйн хуулийн этгээдийг;

4.1.6."аудитын тайлан" гэж аудитын төлөвлөгөөнд заасан зорилго, зорилт, хамрах хүрээнд хийсэн аудитын үр дүнг илтгэсэн, эрх бүхий албан тушаалтны баталгаажуулсан баримт бичгийг;

4.1.7."аудитын төлөвлөгөө" гэж аудит хийх үндэслэл, аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй, цаг хугацаа, хөтөлбөрийг багтаасан эрх бүхий этгээдийн баталсан баримт бичгийг;

4.1.8."санхүүгийн тайлангийн аудит" гэж шалгагдагч этгээд санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхийг шалгаж шийдвэр гаргах үйл ажиллагааг;

4.1.9."гүйцэтгэлийн аудит" гэж шалгагдагч этгээдийн үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний арвилан хэмнэлт, үр ашигтай, үр нөлөөтэй байдлыг шалгаж шийдвэр гаргах үйл ажиллагааг;

4.1.10."нийцлийн аудит гэж" шалгагдагч этгээд нийтийн өмч, санхүү, төсвийг захиран зарцуулах үйл ажиллагаандаа хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актаар тогтоосон шаардлагыг сахин биелүүлж байгаа байдлыг шалгаж шийдвэр гаргах үйл ажиллагааг;

4.1.11."аудитын хуулийн этгээд" гэж Аудитын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан этгээдийг;

4.1.12."аудитын тайлан" гэж аудитын төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын үр дүнг илтгэсэн, эрх бүхий албан тушаалтны баталгаажуулсан баримт бичгийг;

4.1.13."үйлдлийн болон гүйлгээний лог бүртгэл" гэж системд нэвтэрсэн, өөрчлөлт хийсэн, хийхийг завдсан болон санхүүгийн гүйлгээ хийсэн, хийхийг завдсан болон үйлдлийн түүхийг;



4.1.14."нөлөөллийн мэдүүлэг" гэж аудит хийх явцад тухайн аудитын үр дүнтэй холбогдуулан төрийн аудитын байгууллагад аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх гэж оролдсон бүх үйлдлийг тэмдэглэн баталгаажуулсан баримт бичгийг.

5 дугаар зүйл.Төрийн аудитын үндсэн зорилт

5.1.Төрийн аудитын үндсэн зорилт нь нийтийн сан хөмрөгийг хууль ёсны дагуу, арвич хямгач, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулах, хамгаалах, түүнчлэн төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулахад чиглэнэ.

6 дугаар зүйл.Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх

6.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын дагуу төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллага нь төрийн аудитын байгууллага байна.

6.2.Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг зөвхөн энэ хуулиар тогтоох бөгөөд бусад хуулиар төрийн аудитын байгууллагад Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт болон энэ хуулиар тодорхойлсон төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээнд хамаарахгүй чиг үүрэг нэмэгдүүлэхийг хориглоно.

6.3.Төрийн аудитын байгууллага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.3.1.шалгагдагч этгээдэд төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээнд санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийж, хуульд заасан шийдвэр гаргах;

6.3.2.нийтийн сан хөмрөгтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актыг боловсронгуй болгох, батлан гаргах талаар Улсын Их Хурал болон бусад эрх бүхий этгээдэд зөвлөмж өгөх;

6.3.3.Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн жилийн улсын төсвийн төсөл түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж Улсын Их Хурал болон иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах;

6.3.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

6.4.Аудитэд оролцогчийн шалгагдагч этгээдтэй санхүү, эдийн засгийн харилцаанд оролцсон үйл ажиллагаа төрийн аудитад хамрагдана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ АУДИТ ХИЙХ



7 дугаар зүйл.Төрийн аудитын төрөл, хэлбэр

7.1.Төрийн аудит санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит гэсэн төрөлтэй байна.

7.2.Санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх журмыг Ерөнхий аудитор батална.

7.3.Төрийн аудитын байгууллага аудитыг хамтарсан, зэрэгцээ, давтан, завсрын болон бусад хэлбэрээр аудит хийж болно.

8 дугаар зүйл.Цахим мэдээллийн аудит

8.1.Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ шалгагдагч этгээд болон аудитэд оролцогчийн цахим сан, мэдээлэл, гүйлгээ, бүртгэл зэрэгт цахим хэлбэрээр хийгдсэн төрийн санхүү, төсвийн төлөвлөлт, тайлагналт, ашиглалт, зарцуулалт, үйл ажиллагааны үр дүнд аудит хийж болно.

8.2.Төрийн аудитын байгууллага аудитын үр дүнтэй байдал, үнэн зөв, бодитой байх зорилгыг хангахын тулд шалгагдагч этгээдийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа технологи, програм хангамжийг хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хүрээнд, хүний нөлөөлөлгүй ажиллаж байгаа эсэх, технологи, програм хангамжийн орчны аюулгүй байдал, давуу болон сул талыг тодорхойлох эрсдэлийн үнэлгээ хийж болно.

8.3.Цахим мэдээллийн аудит хийх, эрсдэлийн үнэлгээ хийх журмыг Ерөнхий аудитор батална.

9 дүгээр зүйл.Санхүүгийн тайлангийн аудит

9.1.Төрийн аудитын байгууллага Төвсийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан буюу санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит болон тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ.

9.2.Төрийн аудитын байгууллага аудитын сэдэв түүний үндсэн дээр боловсруулан аудитын төлөвлөгөний дагуу төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээдийн санхүүгийн тайланд аудит хийж болно.

9.3.Төрийн аудитын байгууллага Улсын Их Хурлын зөвхөн санхүүгийн тайланд аудит хийх бөгөөд хэрэв Улсын Их Хурлаас хүсэлт гаргасан тохиолдолд Улсын Их Хурлын үйл ажиллагаанд бусад төрөл, хэлбэрээр аудит хийж болно.

9.4.Гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагын гүйцэтгэх ажилд зориулсан улсын төсвийн хөрөнгийн зарцуулалтад Ерөнхий аудиторын санал болгосноор Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооноос итгэмжилсэн аудитор аудит хийнэ. Итгэмжилсэн аудитор нь аудитын төлөвлөгөөгөө өөрөө боловсруулах бөгөөд аудитын тайлангаа Ерөнхий аудиторроор баталгаажуулна.

9.5.Төрийн аудитын байгууллага энэ хуулийн 9.1, 9.2-т зааснаас бусад хуулийн этгээдэд тэдний хүсэлтээр санхүүгийн тайлангийн аудитыг төлбөртэйгөөр



гүйцэтгэж болох бөгөөд уг төлбөрийн хэмжээг Ерөнхий аудиторын саналыг үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

9.6.Энэ хуулийн 9.5-д заасан үйл ажиллагаанаас олсон орлогыг энэ хуулийн 24.3-т заасан нэгжийн үйл ажиллагаанд зарцуулна.

10 дугаар зүйл.Гүйцэтгэлийн болон нийцлийн аудит

10.1.Төрийн аудитын байгууллага аудитын сэдвийн үндсэн дээр боловсруулсан аудитын төлөвлөгөөний дагуу төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээнд шалгадагч этгээдэд гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийнэ.

11 дүгээр зүйл.Аудитын төлөвлөлт

11.1.Ерөнхий аудитор аудитын сэдвийг томъёолон Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороогоор батлуулна.

11.2.Энэ хуулийн 11.1-д заасан аудитын сэдэв нь дараах байдлаар ангилагдана:

11.2.1.хуульд заасны дагуу хийгдэх аудитын сэдэв;

11.2.2.төрийн аудитын байгууллагын бодлогоор хийгдэх аудитын сэдэв.

11.3.Төрийн аудитын байгууллага энэ хуулийн 11.2.2-т заасан аудитын сэдвийг сонгохдоо дараах хүчин зүйлийг харгалзан үзнэ:

11.3.1.тухайн сэдвээр урьдчилсан судалгаа, тооцоолол хийгдсэн байдал;

11.3.2.иргэд, олон нийтийн анхааралд байгаа үнэн зөв хариу хүссэн нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал;

11.3.3.төсөв, санхүү, хугацаа болон хүний нөөцийн чадавхи.

11.4.Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь тухайн орон нутагтаа гүйцэтгэх дөрвөөс илүүгүй аудитын сэдвийг энэ зүйлийн 11.3-т заасан хүчин зүйлийг харгалзан томъёолж Ерөнхий аудиторoor батлуулна.

11.5.Энэ зүйлийн 11.1, 11.4-т заасны дагуу батлагдсан аудитын сэдвийг үндэслэн Ерөнхий аудитор аудитын төлөвлөгөөг жилийн болон хэтийн хугацаагаар боловсруулж батална.

11.6.Төрийн аудитын байгууллага аудитын төлөвлөгөөг шалгадагч этгээдэд тухайн аудит эхлэхээс арван таваас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ.

12 дугаар зүйл.Төлөвлөгөөт бус аудит

12.1.Төрийн аудитын байгууллага төлөвлөгөөт бус аудитыг Улсын Их Хурлын шийдвэр, Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан Хянан шалгах түр хорооны шийдвэр болон хуульд заасан бусад үндэслэлээр хийнэ.



Тайлбар: Энэ зүйлд заасан “хуульд заасан бусад үндэслэл” гэдгийг тухайлбал, Нийтийн сонсголын тухай хуулийн 9.2-т “Төсвийн хяналтын сонсгол явуулах бол төрийн аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна” гэх зэргээр хуульд тусгайлан заасан асуудлаар төрийн аудитын байгууллагаар аудит хийлгэж, дүгнэлт гаргуулах шаардлага үүссэн тохиолдлыг ойлгоно.

12.2.Энэ хуулийн 12.1-д заасны дагуу төрийн аудитын байгууллагаар аудит хийлгэх тохиолдолд холбогдох этгээд нь Ерөнхий аудиторт урьдчилан мэдэгдэж, зөвшилцсөний үндсэн дээр уг аудитын хамрах хүрээ, хугацааг тогтооно.

13 дугаар зүйл.Улсын салбарын олон улсын стандарт

13.1.Төрийн аудитын байгууллага чиг үүргээ гүйцэтгэхдээ Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын байгууллагаас (INTOSAI) баталсан улсын салбарын аудитын олон улсын стандартыг баримтална.

13.2.Үндэсний аудитын газрын дэргэд захиргааны хэм хэмжээний актын шинжийг агуулаагүй аудит хийхтэй холбоотой аргачлал, удирдамж, зааврыг боловсруулах чиг үүрэг бүхий орон тооны бус гишүүдээс бүрдсэн Төрийн аудитын стандартын хороо ажиллана.

13.3.Төрийн аудитын стандартын хороо нь Ерөнхий аудиторын шийдвэрээр томилогдсон эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэл, эрх зүйн чиглэлээр мэргэшсэн есөөс доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

13.4.Төрийн аудитын стандартын хороо нь дараах чиг үүрэгтэй:

13.4.1.улсын салбарын аудитын олон улсын стандартын албан орчуулгыг хянан, хэрэглээний тайлбар, зөвлөмжийг батлах;

13.4.2.улсын салбарын үндэсний стандарт батлах;

13.4.3.улсын салбарын аудит хийхтэй холбоотой дотоод аргачлал, удирдамж, зааврыг боловсруулж батлах.

13.4.Төрийн аудитын стандартын хорооны дүрэм, хорооны гишүүдэд олгох урамшууллын хэмжээг Ерөнхий аудиторын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо батална.

14 дүгээр зүйл.Мэдээлэл авах эрх

14.1.Төрийн аудитын байгууллагын албан хаагч нь аудит хийхдээ мэдээлэлээр бүрэн хангагдах зарчмын хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1.ямар хэлбэртэй байхаас нь үл хамааран шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг шалгагдагч этгээд болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнаас тогтоосон хугацаанд, үнэ төлбөргүйгээр гаргуулах, хуулбарлаж авах;

14.1.2.шалгагдагч этгээдийн ажлын байр болон бусад холбогдох газарт ажлын цагаар саадгүй нэвтрэн орох, ажиллах, бүртгэл, тооллого хийх, мэдээлэл, баримт бичиг болон бусад эд зүйлстэй үнэ төлбөргүйгээр танилцах;



14.1.3.шалгагдагч этгээдийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа тоног төхөөрөмж, программ хангамж, мэдээллийн санд нэвтрэх, цахим мэдээлэл, баримт бичигтэй танилцах, уг мэдээлэл, баримт бичгийг цахим болон бусад хэлбэрээр хувиран авах;

14.1.4.шалгагдагч этгээдээс тайлбар гаргуулах, тодорхой асуулт тавьж хариулт авах;

14.1.5.шаардлагатай тохиолдолд мэдээлэл, баримт бичгийг хамгаалах зорилгоор шалгагдагч этгээдийн агуулах, өрөө, сейф, програм хангамжийн эх код, бүртгэлийн болон гүйлгээний лог бүртгэлийг түр хугацаагаар битүүмжлэх. Ийнхүү битүүмжилсэн хугацаанд шалгагдагч этгээд нь тухайн аудитыг хийхэд шаардагдах хамгийн бага хугацаа байх бөгөөд уг хугацаанд мэдээлэл, баримтыг ашиглах, бусдад дамжуулахыг хориглоно.

14.2.Энэ хуулийн 9.4-т зааснаас бусад тохиолдолд Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ зөвхөн Ерөнхий аудитор, түүний эрх олгосон төрийн аудитын байгууллагын албан хаагч шалгагдагч этгээдийн төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл, баримт бичиг болон түүнчлэн шалгагдагч этгээдтэй санхүү, эдийн засгийн харилцаанд оролцсон байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл, баримт бичгийн зөвхөн тухайн харилцаатай холбогдох хэсэгтэй танилцах эрхтэй.

14.3.Төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл, баримт бичигтэй танилцсан төрийн аудитын байгууллагын албан хаагч уг мэдээлэл, баримт бичгийг холбогдох хуульд заасны дагуу нууцлах үүрэг хүүлэнэ.

14.4.Нууц гэдгээр халхавчлан аудитэд шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг нуун дарагдуулах нь улс орны эрх ашигт харш гэж Ерөнхий аудитор үзвэл уг мэдээлэл, баримт бичгийг авах эрхтэй байгууллага, албан тушаалтанд энэ талаар танилцуулах ба уг байгууллага, албан тушаалтан нь шаардлагатай арга хэмжээг авна.

15 дугаар зүйл.Шалгагдагч этгээдийн үүрэг

15.1.Шалгагдагч этгээд дараахь үүрэгтэй:

15.1.1.төрийн аудитын байгууллагын албан хаагчийг аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах;

15.1.2.төрийн аудитын байгууллагын албан хаагчийг ажлын байр, холбогдох бусад холбогдох газарт чөлөөтэй нэвтрүүлэх, ажиллах өрөө, тасалгаа, нөхцөл, боломжоор хангах;

15.1.3.төрийн аудитын байгууллагын албан хаагчийн үйл ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохгүй байх;

15.1.4.шалгагдагч этгээд төрийн аудитын байгууллагаас тогтоосон журам, хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх;



15.1.5.төрийн аудитын байгууллагын албан хаагчидтай харилцах, туслах үүргийг тодорхой ажилтандаа хариуцуулах;

15.1.6.хуульд заасан бусад үүрэг.

16 дугаар зүйл.Санхүүгийн тайлангийн аудитыг аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх

16.1.Төрийн аудитын байгууллага энэ хуульд заасан санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ хараат бус аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болох бөгөөд энэ тохиолдолд төрийн аудитын байгууллага аудитын хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэн зөв, шударгаар илэрхийлэгдсэн байдлыг үнэлэн, түүнд тулгуурлан санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт гаргана.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан аудитын хуулийн этгээдийг хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулах бөгөөд аудитын хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, баталгаажуулах журмыг Ерөнхий аудитор батална.

17 дугаар зүйл.Аудит хийхэд шинжээч, мэргэжилтэн оролцуулах

17.1.Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээч, мэргэжилтнийг өөртэй нь тохиролцсоны үндсэн дээр Ерөнхий аудиторын шийдвэрээр томилон ажиллуулж болно.

17.2.Шинжээч, мэргэжилтэн нь аудитыг хийхэд шаардагдах тодорхой ажлыг гүйцэтгэх өндөр мэдлэг, ур чадвартай хувь хүн байна.

17.3.Шинжээч, мэргэжилтэн нь төрийн аудитын байгууллагаас олгосон эрх хэмжээний хүрээнд ажиллана.

17.4.Төрийн аудитын байгууллага энэ зүйлийн 17.2-т заасан шинжээч, мэргэжилтний мэдээллийн санг үүсгэж, өөрийн цахим хуудсаараа нийтэд нээлттэй мэдээллэнэ.

17.5.Шинжээч, мэргэжилтнийг сонгохдоо аудит хийх тухайн салбар, чиглэлээр мэргэшсэн байдал, хөндлөнгийн, хараат бус байх шаардлагыг үндэслэл болгоно.

17.6.Энэ хуулийн 17.2-т заасан шинжээч, мэргэжилтнийг сонгоход Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль үйлчлэхгүй бөгөөд нарийвчилсан журмыг Ерөнхий аудитор батална.

18 дугаар зүйл.Аудитэд оролцогчийн тайлбар, саналыг сонсох

18.1.Төрийн аудитын байгууллага аудитын тайлангийн үр дүн, шийдвэрийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй аудитэд оролцогчийг Захиргааны ерөнхий хуулийн 13 дугаар зүйлд зааснаар тодорхойлж, тайлбар, санал гаргах боломжийг олгоно.

19 дүгээр зүйл.Аудитын тайлангийн төсөлд саналд авах



19.1.Төрийн аудитын байгууллага аудитын тайлангийн төсөл бэлэн болсны дараа шалгагдагч этгээдэд аудитын тайлангийн төслийг хүргүүлнэ.

19.2.Шалгагдагч этгээдэд аудитын тайлангийн төсөлд санал өгөх тохиолдолд саналаа 7 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ.

19.3.Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээд энэ хуулийн 19.2-т заасны шалгагдагч этгээдээс ирүүлсэн саналыг судлан үндэслэлтэй гэж үзвэл тайланд засвар оруулах, үндэслэлгүй гэж үзвэл өөрийн дүгнэлтийг нэмэлт нотлох зүйлээр бататгах арга хэмжээ авна.

19.4.Шалгагдагч этгээд энэ хуулийн 19.2-т заасан хугацаанд аудитын тайлангийн төсөлд санал ирүүлээгүй тохиолдолд саналгүйд тооцно.

20 дугаар зүйл.Төрийн аудитын бүтээгдэхүүн

20.1.Төрийн аудитын бүтээгдэхүүн нь дүгнэлт байна. Энэ хуульд заасны дагуу аудит хийж дүгнэлт, зөвлөмж үйлдэх нь төрийн аудитын байгууллагаас төрийн санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх үндсэн арга, ажиллагаа байна.

20.2.Төрийн аудитын байгууллага аудитын тайлангийн үр дүнд тулгуурлан нийтийн сан хөмрөгийг холбогдох хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актын хүрээнд төлөвлөх, хуваарилах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагааны арвилан хэмнэлт, үр ашигтай, үр нөлөөтэй байдал, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах зорилгоор зөвлөмж үйлдэх бөгөөд энэ нь аудитын тайлангийн салшгүй хэсэг байна.

21 дүгээр зүйл.Албан шаардлага, акт үйлдэх

21.1.Төрийн аудитын байгууллага аудитаар илэрсэн зөрчлийг таслан зогсоох, арилгуулах, давтан гаргуулахгүй байх талаар, мөн өмнө нь өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангуулах зорилгоор албан шаардлага үйлдэнэ.

21.2.Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээд үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад дүрэм, журам болон гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ, хэлцлээр тохирсон үүргээ мөрдөж ажиллаагүйгээс төсвийн хөрөнгөд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор, түүнчлэн Захиргааны ерөнхий хуулийн 103.3-т заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар төрд учруулсан хохирлыг төлүүлэх зорилгоор акт үйлдэнэ.

21.3.Төрийн аудитын байгууллага энэ хуулийн 21.1, 21.2-т заасны дагуу албан шаардлага, акт үйлдсэн тохиолдолд тэдгээр нь аудитын тайлангийн салшгүй хэсэг байна.

21.4.Зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актад түүнийг үйлдсэн албан тушаалтны нэр, гарын үсэг, гаргасан шийдвэр, тухайн шийдвэрийг гаргах үндэслэл, биелүүлэх хугацааг тусгана.

21.5.Акт, албан шаардлагын загварыг Ерөнхий аудитор батална.

22 дугаар зүйл.Акт, албан шаардлагыг мэдэгдэх



22.1.Төрийн аудитын байгууллага албан шаардлага актыг шалгагдагч этгээд болон уг шийдвэрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бусад этгээдэд Захиргааны ерөнхий хуульд заасан журмаар мэдэгдэнэ.

23 дугаар зүйл. Акт, албан шаардлагын биелэлтийг хангах

23.1.Төрийн аудитын байгууллага хүчин төгөлдөр болсон албан шаардлага, актыг Захиргааны ерөнхий хуулийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БҮРЭЛДЭХҮҮН

24 дүгээр зүйл. Төрийн аудитын байгууллагын тогтолцоо

24.1.Төрийн аудитын байгууллагыг Ерөнхий аудитор удирдана.

24.2.Төрийн аудитын байгууллага нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх бөгөөд төрийн аудитын дээд байгууллага буюу Үндэсний аудитын газар, түүний харьяа аймаг, нийслэл дэх төрийн аудитын газраас бүрдэнэ.

24.3.Үндэсний аудитын газрын дэргэд төрийн аудитын байгууллагын албан хаагчийг мэргэшүүлэх, аудиттэй холбогдсон судалгаа, шинжилгээ хийх, аудитын чадавхыг бэхжүүлэх чиг үүрэг бүхий сургалтын болон мэдээлэл технологийн төвийг байгуулж болно.

24.4.Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг Ерөнхий аудиторовн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батлах бөгөөд уг орон тоо нь энэ хууль болон бусад хуулиар ногдуулсан чиг үүргээ тогтоосон цаг хугацаанд, бүрэн хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц байна. Энэ шаардлага хангагдаагүй нөхцөлд төрийн аудитын байгууллага үүнээс үүдсэн ажлын алдаа, дутагдлыг хариуцахгүй.

24.5.Ерөнхий аудитор энэ хуулийн 24.4-т заасны дагуу батлагдсан орон тооны дээд хязгаарыг үндэслэн төрийн аудитын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоо, газар нэгжийн чиг үүргийг батална.

24.6.Төрийн аудитын байгууллага бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний тодорхойлолт, загвар, хэрэглэх журмыг Ерөнхий аудитор батална.

24.7.Төрийн аудитын байгууллага тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

25 дугаар зүйл. Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн бүрэлдэхүүн, ангилал, зэрэг дэв

25.1.Төрийн аудитын байгууллагад Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний орлогч, тэргүүлэх аудитор, аудитын менежер, ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч ажиллах бөгөөд тэдгээр нь төрийн тусгай албан хаагч байна.

25.2.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийг дор дурдсанаар ангилна:



- 25.2.1.төрийн аудитын тэргүүн түшээ;
- 25.2.2.төрийн аудитын итгэмжит түшээ;
- 25.2.3.төрийн аудитын зөвлөх түшээ;
- 25.2.4.төрийн аудитын шадар түшээ;
- 25.2.5.төрийн аудитын ахлах түшээ;
- 25.2.6.төрийн аудитын түшээ.

25.3.Төрийн аудитын тэргүүн түшээ ангилаллын албан тушаалд Монгол Ерөнхий аудитор, төрийн аудитын итгэмжит түшээ ангилаллын албан тушаалд Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч, төрийн аудитын зөвлөх түшээ ангилаллын албан тушаалд төрийн аудитын байгууллагын тэргүүлэх аудитор, төрийн аудитын шадар түшээ ангилаллын албан тушаалд төрийн аудитын байгууллагын аудитын менежер, төрийн аудитын ахлах түшээ ангилаллын албан тушаалд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, төрийн аудитын түшээ ангилаллын албан тушаалд төрийн аудитын байгууллагын аудитор, шинжээчийн албан тушаал тус тус хамаарна.

25.4.Төрийн аудитын тэргүүн түшээ, итгэмжит түшээ, зөвлөх түшээ, ахлах түшээ, түшээ, дэс түшээ нь тус бүртээ тэргүүн зэрэг, дэд зэрэг, гутгаар зэрэг, дөтгөөр зэрэг гэсэн зэрэг дэвтэй байна.

25.5.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн зэрэг дэвийг олгох журмыг Улсын Их Хурал тогтооно.

25.6.Төрийн аудитын байгууллага нь үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах үүрэг бүхий төрийн захиргаа, үйлчилгээний ажилтантай байна.

26 дугаар зүйл.Төрийн аудитын байгууллагын албан хаагчид тавигдах шаардлага

26.1.Төрийн аудитын байгууллагын албан хаагчаар Төрийн албаны тухай хуульд заасан төрийн жинхэнэ албан хаагчид тавигдах нийтлэг шаардлагыг хангасан, төрийн аудитын байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшсэн иргэнийг ажиллуулна.

26.2.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрмийг Ерөнхий аудитор батална.

26.3. Ерөнхий аудитор төрийн аудитын байгууллагын албан хаагч, бусад ажилтны ажлын байрны тодорхойлолтыг батална.

26.4.Ерөнхий аудитор төрийн аудитын байгууллагын албан хаагчид зориулсан байнгын сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

26.5.Ерөнхий аудитор өөрийн болон бусад албан хаагч, ажилтны гэр бүлийн гишүүн, төрөл, садны хүнийг төрийн аудитын байгууллагад авч ажиллуулахыг хориглоно.

26.6.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Төрийн аудитын байгууллагын албан хаагч, бусад ажилтны эрх зүйн байдлыг Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжоор зохицуулна.



27 дугаар зүйл.Төрийн аудитын байгууллагын алба хаагчийн тангараг

27.1.Төрийн аудитын байгууллагын албан хаагч нь “Төрийн аудитын байгууллагын ажилтан би хөндлөнгийн аливаа нөлөөнд үл автан, гагцхүү хуульд захирагдан үйл ажиллагаагаа явуулж, төрийн аудитын байгууллагын алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая. Тангарагаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.” хэмээн тангараг өргөнө.

27.2.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн тангараг өргөх ёслолыг “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-д заасны дагуу зохион байгуулна.

28 дугаар зүйл.Ерөнхий аудитор

28.1.Ерөнхий аудиторыг нээлттэйгээр нэр дэвшсэн этгээдүүдийн дундаас Улсын Их Хурлын Эдийн засгийн, Төсвийн болон Хууль зүйн байнгын хорооноос хэлэлцэн нэр дэвшүүлсэн хүмүүсээс Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.

28.2.Ерөнхий аудитороор томилогдох хүн Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

28.2.1. 45 нас хүрсэн байх;

28.2.2.эдийн засаг, санхүү эсхүл хууль зүйн чиглэлээр дээд боловсролын зэрэгтэй байх;

28.2.3.төрийн албанд 10-аас дээш жил ажилласан байх;

28.2.4.сүүлийн 6 жилийн хугацаанд улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн идэвхитэй үйл ажиллагаа явуулаагүй байх.

28.3.Ерөнхий аудитор нь төрийн өндөр албан тушаалтны зэрэг, зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалтны зэрэглэлд тохирсон цалин хөлс авч, зайлшгүй шаардлагатай бусад хангамж эдэлж, хуульд заасан баталгаагаар хангагдана.

28.4.Ерөнхий аудиторын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, эсхүл хугацаанаас өмнө чөлөөлсөн, огцруулсан бол Улсын Их Хурал энэ хуульд заасан журмын дагуу Ерөнхий аудиторыг 30 хоногийн дотор нөхөн томилно.

28.5.Улсын Их Хурал Ерөнхий аудиторын бүрэн эрхийг түдгэлзүүлсэн эсхүл бүрэн эрхийг хугацаанаас нь дуусгавар болгосон тохиолдолд дараагийн Ерөнхий аудиторыг томилох хүртэл хугацаанд Ерөнхий аудиторын орлогч нараас аль нэгийг нь Ерөнхий аудиторын бүрэн эрхийг хэрэгжүүлүүлэхээр түр томилно.

29 дүгээр зүйл. Ерөнхий аудиторын бүрэн эрх

29.1.Монгол Улсын Ерөнхий аудитор дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

29.1.1.төрийн аудитын байгууллагыг нэгтгэн зохион байгуулж, удирдах;

29.1.2.төрийн аудитын байгууллагыг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;



29.1.3.бүрэн эрхийнхээ хүрээнд дүрэм, журам, заавар, аргачлал, стандарт батлах;

29.1.4.Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос баталсан гүйцэтгэх аудитын сэдвийн хүрээнд аудитын төлөвлөгөөг хянаж батлах;

29.1.5.төрийн аудитын байгууллагын төсвийг хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих;

29.1.6.Улсын Их Хурлын чуулганы болон Засгийн газрын хуралдаанд зөвлөх эрхтэй оролцох;

29.1.7.Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны баталсан орон тооны дээд хязгаарыг үндэслэн төрийн аудитын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоог батлах;

29.1.8.Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн аудитын байгууллагын албан хаагч, бусад ажилтныг томилох, чөлөөлөх, сэлгэн ажиллуулах, зэрэг дэв олгох, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах;

29.1.9.аудитын бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор комисс болон тусгай ажлын хэсэг байгуулах;

29.1.10.аудитын тайлангийн дүгнэлтийг баталгаажуулах;

29.1.11.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

29.2.Ерөхий аудитор энэ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ зарим хэсгийг Ерөнхий аудиторын орлогч болон тэргүүлэх аудиторт шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь Ерөнхий аудиторыг энэ хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

29.3.Ерөнхий аудитор бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал гаргана.

29.4.Ерөнхий аудиторын орлогч болон Тэргүүлэх аудитор нь Ерөнхий аудитороос олгосон бүрэн эрхийн эрхээнд тушаал гаргана.

30 дугаар зүйл.Ерөнхий аудиторыг чөлөөлөх, огцруулах

30.1.Ерөнхий аудиторыг дараах тохиолдолд үүрэгт ажлаас нь чөлөөлнө:

30.1.1.бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;

30.1.2.албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан;

30.1.3.тэтгэврийн насанд хүрсэн;

30.1.4.эрүүл мэндийн байдлын шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

30.1.5.Монгол Улсын харьяатаас гарсан, эсхүл гадаад улсын нутаг дэвсгэрт байнга оршин суух эрх авсан;

30.1.6.өөрийнх нь зөвшөөрснөөр өөр ажил, албан тушаалд томилсон, хуульд заасны дагуу сонгогддог албан тушаалд нэр дэвшсэн;



30.1.7.иргэний эрх зүйн чадамжийг нь хязгаарласан, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйг тогтоосон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

30.1.8.эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах тухай шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

30.1.9.нас барсан, эсхүл нас барсан болон сураггүй алга болсонд тооцох тухай шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон.

30.2.Ерөнхий аудиторыг дараах тохиолдолд албан тушаалаас нь огцруулна:

30.2.1.Ерөнхий аудиторын албан тушаалтай хавсарч үл болох үйл ажиллагаа эрхэлсэн;

30.2.2.гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон.

30.3.Улсын Их Хурал Ерөнхий аудиторын бүрэн эрхийг түдгэлзүүлсэн, эсхүл бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болсон тохиолдолд дараагийн Ерөнхий аудиторыг томилох хүртэл хугацаанд Ерөнхий аудиторын орлогч нарын аль нэгийг Ерөнхий аудиторoor түр томилно.

31 дүгээр зүйл.Тусгай аудитор

31.1.Тогтвортой хөгжлийн зорилго, хөгжлийн бодлогын үзэл баримтлал, төлөвлөлт, хүрээлэн буй орчныг хамгаалах асуудлаар Ерөнхий аудиторт чиг үүргээ хэрэгжүүлэхэд туслах тусгай аудиторыг Ерөнхий аудитор томилно.

31.2.Тусгай аудитор Ерөнхий аудиторын баталсан стандарт, журмын дагуу аудит хийнэ. Томилогдсон аудитор аудит хийх хугацаандаа мэдээлэл цуглуулах талаар төрийн аудитын байгууллагын албан хаагчийн бүрэн эрхийг нэгэн адил эдэлнэ.

32 дугаар зүйл.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн үүрэг

32.1.Төрийн аудитын байгууллагын албан хаагч нь дараахь үүрэг хүлээнэ:

32.1.1.шалгагдагч этгээдэд аудитын төрөл, зорилго, аудит хийх хамрах хүрээ, хугацаа, талуудын эрх, үүргийн талаар тайлбарлах;

32.2.2.аудитын тайлангийн төслийг бэлтгэх хүртлээ аудитын ажлын үр дүнг нууцлах;

32.2.3.төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх;

32.2.4.шалгагдагч этгэдийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд саад болохоос зайлсхийх;

32.2.5.хуульд заасан бусад үүрэг.

33 дугаар зүйл.Төрийн аудитын байгууллагад хийх аудит



33.1.Төрийн аудитын байгууллагын жилийн санхүүгийн тайланг тухай бүр сонгон шалгаруулж, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос томилсон хараат бус мэргэжлийн аудитор шалгаж, дүнг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулна.

33.2.Томилогдсон аудитор Ерөнхий аудиторын баталсан стандарт, журмын дагуу аудит хийнэ. Томилогдсон аудитор аудит хийх хугацаандаа мэдээлэл цуглуулах талаар төрийн аудитын байгууллагын албан хаагчийн бүрэн эрхийг нэгэн адил эдэлнэ.

33.3.Томилогдсон аудитор төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд ямар нэгэн хэлбэрээр нөлөөлөхийг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС БУСАД БАЙГУУЛЛАГА, ИРГЭДТЭЙ ХАРИЛЦАХ, ИЛ ТОД БАЙДАЛ

34 дүгээр зүйл.Ерөнхий аудитор Улсын Их Хуралтай харилцах

34.1.Ерөнхий аудитор төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны жилийн тайланг тухай бүр Улсын Их Хуралд танилцуулна.

34.2.Төрийн аудитын байгууллага тухайн жилд гүйцэтгэсэн аудитын тайланг тухай бүр Улсын Их Хуралд хүргүүлнэ.

34.3.Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо улсын нэгдсэн төсвийн төсөл, гүйцэтгэлийг хэлэлцэхдээ төрийн аудитын байгууллагаас төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмж, түүний биелэлтийг харгалзан үзэх ба энэ талаарх Ерөнхий аудиторын танилцуулгыг сонсож болно.

34.4.Ерөнхий аудитор нь өөрийн үйл ажиллагааны хараат бус байдал, төсөв, санхүү, зохион байгуулалттай холбоотой асуудлаар Улсын Их Хуралд санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

34.5.Ерөнхий аудитор нийтийн ашиг сонирхолд хамаарах аливаа асуудлаар санал, зөвлөмж бэлтгэж Улсын Их Хуралд танилцуулж болно.

35 дугаар зүйл.Ерөнхий аудитор Засгийн газартай харилцах

35.1.Ерөнхий аудитор Засгийн газар, түүний харьяа захиргааны байгууллага нь төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, үйлдсэн албан шаардлага, актын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг Засгийн газарт хүргүүлж, зохих шийдвэрийг гаргуулна.

35.2.Засгийн газар зохих шийдвэрийг гаргаагүй тохиолдолд Ерөнхий аудитор уг асуудлыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулах бөгөөд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо уг асуудлыг хэлэлцэж хуульд заасны дагуу Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгсөн шийдвэрийг гаргана.



36 дугаар зүйл.Ерөнхий аудитор хууль сахиулах байгууллагатай харилцах

36.1.Аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд Ерөнхий аудитор энэ тухай эрх бүхий байгууллагад мэдэгдэж холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлэн шалгуулна. Эрх бүхий байгууллага Ерөнхий аудиторын шилжүүлсэн мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан гаргасан шийдвэрээ холбогдох хуульд заасан хугацаанд Ерөнхий аудиторт мэдэгдэнэ.

37 дугаар зүйл.Төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг төлүүлэх үүргийн хэрэгжилтийг мэдээллэх

37.1.Төрийн аудитын байгууллага тухайн жилд Захиргааны ерөнхий хуулийн 103.3-т заасны дагуу төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг төлүүлэх үүргийн биелэлтийг Улсын Их Хурлын Байнгын Төсвийн хороонд жил бүрийн 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулах ба уг мэдээллийг Үндэсний аудитын газрын цахим хуудсанд олон нийтэд нээлттэй танилцах боломжтойгоор байршуулна.

37.2.Төрийн аудитын байгууллагын Захиргааны ерөнхий хуулийн 103.3-т заасан үүргийг хэрэгжүүлэх журмыг Ерөнхий аудитор баталж, мөрдүүлнэ.

38 дугаар зүйл.Төрийн аудитын нээлттэй, ил тод байдлыг хангах

38.1.Төрийн аудитын байгууллага төрийн болон албаны, байгууллагын, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайланг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхий тухай хуулийн Хоёрдугаар бүлэгт заасан журмын дагуу улирал тутам гаргаж, өөрийн цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

38.2.Төрийн аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааны тайланг өөрийн цахим хуудаст нийтэд нээлттэй, ил тод байршуулна.

38.3.Төрийн аудитын байгууллага хүсэлт гаргасан этгээдэд төрийн болон байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайланг хүссэн хэлбэр (хэвлэмэл, цахим)-ээр нь өгнө.

38.4.Төрийн аудитын байгууллага энэ хуулийн 38.3-т заасан үйлчилгээг төлбөртэйгөөр гүйцтгэж болох бөгөөд уг төлбөрийн хэмжээг Ерөнхий аудитор тогтооно.

38.5.Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх болон хуулиар хориглосноос бусад тохиолдолд Ерөнхий аудитор, түүний зөвшөөрснөөр төрийн аудитын байгууллагын албан хаагч аудитын явцын талаар олон нийт, албан тушаалтан, хүн, хуулийн этгээдэд мэдээлэл өгч болно.

ТАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН АУДИТЫН БАТАЛГАА

39 дүгээр зүйл.Хууль зүйн баталгаа



39.1.Ерөнхий аудиторыг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

39.2.Ерөнхий аудиторыг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол холбогдох албан тушаалтан энэ тухай Улсын Их Хуралд 24 цагийн дотор мэдэгдэнэ. Улсын Их Хурал 48 цагийн дотор баривчлах зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд Ерөнхий аудиторыг нэн даруй суллана.

39.3.Ерөнхий аудиторт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан шалгахтай холбогдуулан бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

39.4.Ерөнхий аудиторыг энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр албан тушаалаас нь чөлөөлөх, огцруулах, түдгэлзүүлэх, түүнчлэн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд томилохыг хориглоно.

39.5.Ерөнхий аудиторыг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр, төрийн аудитын байгууллагын албан хаагчийг Ерөнхий аудиторын зөвшөөрөлгүйгээр аудит хийх бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа шударгаар мэдүүлсэн үг, гаргасан дүгнэлт, тайлан, хийсэн аливаа мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр асуухыг хориглоно.

39.6.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийг энэ хууль болон бусад хуулиар олгосон аудит хийх бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд эсхүл хэрэгжүүлэх явцдаа шударгаар мэдүүлсэн үг, гаргасан дүгнэлт, тайлан, хийсэн аливаа мэргэжлийн үйл ажиллагааных нь эсрэг эрүүгийн, зөрчлийн болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахыг хориглоно.

39.7.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн болон Засгийн газрын гишүүн, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус, бусад аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч төрийн аудитын байгууллагын албан хаагчаас аудит хийх бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.

39.8.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийг аудит хийх чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хөндлөнгөөс нөлөөлсөн, дарамт, шахалт үзүүлсэн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

39.9.Ерөнхий аудитор төрийн аудитын байгууллагын бусад албан хаагчийн хараат бус байдлыг хангах арга хэмжээ авах үүрэгтэй.

40 дүгээр зүйл.Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх

40.1.Төрийн аудитын байгууллагын албан хаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулсан, аливаа дарамт, шахалт, хууль бус нөлөөллийн талаар Ерөнхий аудиторт мэдүүлэх үүрэгтэй.

40.2.Төрийн аудитын байгууллагын албан хаагч аудит хийхдээ нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.



40.3.Энэ хуулийн 40.2-т заасан нөлөөллийн мэдүүлгийн маягт, зааврыг Ерөнхий аудитор батална.

40.4.Аудит хийж эхэлсэн даруйд нөлөөллийн мэдүүлгийн зорилго, хууль зөрчсөнөөс үүсэх үр дагаврын талаар шалгагдагч этгээдийн эрх бүхий албан тушаалтанд тайлбарлан, гарын үсэг зуруулж баримтжуулна.

40.5.Нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн төрийн аудитын байгууллагын албан хаагч нөлөөллийн мэдүүлгийг эх хувийг аудитын тайланд хавсарган, хуулбар хувийг Ерөнхий аудиторт хүргүүлнэ.

40.6.Ерөнхий аудитор энэ хуулийн 40.2-т заасан нөлөөллийн мэдүүлэгт тэмдэглэн баталгаажуулсан тухайн этгээдийн үйлдлийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад хандаж, шийдвэрлүүлнэ.

40.7.Эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 40.6-д заасны дагуу Ерөнхий аудиторын ирүүлсэн хүсэлтийг хуульд заасны дагуу шийдвэрлэж, Ерөнхий аудиторт хариу мэдэгдэнэ.

40.8.Төрийн аудитын байгууллага нь энэ хуулийн 40.7-д заасны дагуу эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хариуг өөрийн цахим хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тухай бүрд нь мэдээлнэ.

41 дүгээр зүйл.Эдийн засгийн баталгаа

41.1.Төрийн аудитын байгууллага улсын төсвөөс санхүүжнэ. Төрийн аудитын байгууллагын төсөв нь төрийн аудитын байгууллага үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй байна.

41.2.Ерөнхий аудитор төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороогоор хянуулна.

41.3.Ерөнхий аудитор Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороогоор хянагдаж зөвшөөрөгдсөн төсвийн төслийг улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороогоор хянагдаж зөвшөөрөгдсөн төрийн аудитын байгууллагын төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын нэгдсэн төсвийн төсөлд нэгтгэнэ.

41.4.Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо энэ хуулийн 41.2-т заасны дагуу хянагдаж, зөвшөөрөгдсөн төрийн аудитын байгууллагын төсвийг бууруулахгүй байх талаар шаардлагатай арга хэмжээг авна.

41.5.Төрийн аудитын байгууллагын төсвийн төсөлд төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны зардлаас гадна аудитын хараат бус аудитын хуулийн этгээд шинжээч, мэргэжилтэн авч ажиллуулах зардал, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааны асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах хөрөнгийг тусгана.



42 дугаар зүйл.Нийгмийн баталгаа

42.1.Төрийн аудитын байгууллагын аудитор Төрийн албаны тухай хууль тогтоомжид заасан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа, нэмэгдэл баталгаа, цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал урамшил, тэтгэмжээс гадна энэ хуульд заасан баталгаагаар хангагдана.

42.2.Төрийн аудитын байгууллагын албан хаагч Төрийн албаны тухай хууль тогтоомжид зааснаас гадна дор дурдсан нэмэгдэл баталгаагаар хангагдана:

42.2.1.аудит хийх бүрэн эрхээ хэрэгжүүлж явахдаа хот, суурин газрын доторхи нийтийн тээврийн хэрэгсэл (таксинаас бусад)-ээр зорчсон тохиолдолд хувиас гарсан зардлыг Ерөнхий аудиторын баталсан журмын дагуу төрийн аудитын байгууллагын төсвийн хөрөнгөөс нөхөн олгох;

42.2.2.аудит хийх бүрэн эрхээ хэрэгжүүлж явцад хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж, албан тушаалын цалингийн зөрүүг хөдөлмөрийн чадвараа түр алдсан хугацааны туршид, хөгжлийн бэрхшээлтэй болсон бол тахир дутуугийн тэтгэвэр, албан тушаалын цалингийн зөрүүг тахир дутуугийн тэтгэвэр авч байгаа хугацааны туршид тус тус авах;

42.2.3.аудит хийх бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан амь насыг нь хохироосон тохиолдолд түүний албан тушаалын гурван жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг хохирогчийн гэр бүлд нь олгох.

42.3.Энэ зүйлийн 42.2.2, 42.2.3-т заасан тэтгэвэр, тэтгэмж болон албан тушаалын цалингийн зөрүү, буцалтгүй тусламжийг улсын төсвөөс олгож, уг хөрөнгийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

42.4.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн нэмэгдлээс бүрдэх бөгөөд тэдгээрийн хэмжээг цалин хөлсний нэмэгдэл, Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн дундаж цалинд тус тус үндэслэн Ерөнхий аудиторын санал болгосноор Улсын Их Хурал тухай бүр тогтооно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

43 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

43.1.Санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээдийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, санхүүгийн тайлангийн аудитаар удаа дараа (2 буюу түүнээс дээш удаа) хязгаарлалтай дүгнэлт авсан, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, актыг биелүүлээгүй, зөвлөмжид заасан ажлыг хэрэгжүүлж тогтоосон хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу ирүүлээгүй, төрийн аудитын байгууллага бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь саад саад учруулсан нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр удаа дараа тогтоогдсон нь тухайн төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн



өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгжийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

43.2.Төрийн аудитын байгууллага энэ хуулийн 43.1-д заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэл хүргүүлэх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн мэдэгдэлд заасан хугацаанд хариу ирүүлнэ.

43.3.Энэ хуулийн 43.1, 43.2-т заасны дагуу тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулахад бусад хуульд заасан үндэслэл, журам үйлчлэхгүй.

43.4.Энэ хуулийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

43.5.Энэ хуулийг зөрчсөн төрийн аудитын байгууллагын албан хаагчид Төрийн албаны тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

44 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

44.1.Энэ хуулийг 2019 оны дүгээр сарын-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн Арван тавдугаар бүлэгт дор дурьдсан агуулгатай зүйл нэмсүгэй:

“15.29 дүгээр зүйл.Төрийн аудитын байгууллага бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулах

1.Төрийн аудитын байгууллагаас шаардсан мэдээлэл, баримт бичиг, тайлбарыг гаргаж өгөхөөс татгалзах, танилцах боломж олгохгүй байх, төрийн аудитын байгууллагын албан хаагчийг ажлын байр болон бусад холбогдох газарт нэвтрүүлэх, ажиллах нөхцөл, боломжоор хангахгүй байх, төрийн аудитын байгууллагын албан хаагчийг аудит хийх бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд аливаа хэлбэрээр нөлөөлөх, доромжлох, халдах, эсэргүүцэхийг оролдох, бусад хэлбэрээр аудит хийлгэхээс зайлсхийх зэргээр төрийн аудитын байгууллагаа бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулсан бол хүнийг хоёр зуун нэгж, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжээр торгоно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн аудитын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.8 дахь заалтын “15.24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчил,” гэсний дараа “15.29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн аудитын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт дараах агуулгатай заалт нэмсүгэй:

“7.2.11.Төрийн аудитын байгууллага аудит хийх хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн аудитын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“37.1.Төрийн аудитын байгууллага газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хянаж, дүгнэлт гаргасан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын тайланд жил бүр аудит хийнэ.”

2 дугаар зүйл. Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн аудитын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дахь заалтын “иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх,” гэсний дараа “төсвийн төслийг төрийн аудитын байгууллагад хүргүүлэх” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн аудитын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг